

Тайлан хянасан:

УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ
ЭМНЭЛГИЙН ЗАХИРАЛ
(албан тушаал)



Э.АНХБАЯР

УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ ЭМНЭЛГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНЫ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮНДЭСНИЙ
ХӨТӨЛБӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

2025 ОН

№	ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХҮРЭХ ҮР ДҮН	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	ХЭРЭГЖИЛТ
1	2	3	4	5
Зорилт 1. Ажлын байрны хэрэгцээ, шаардлагад нийцсэн чадварлаг, мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэх				
1.1	Байгууллагын бүтэц, үйл ажиллагааны стандартад нийцүүлэн ажлын байрны хэрэгцээг тодорхойлон, хүний нөөц бүрдүүлэлтийг дотоод болон гадаад нөөцөөс бүрдүүлэх	хүний нөөцийн зохистой харьцаа бүрдэнэ	Батлагдсан орон тооны хангалтын хувь	Хүний нөөцийн удирдлагад ил тод байдлыг хэрэгжүүлэх зорилгоор “Эрүүл мэндийн ажилтан сонгон шалгаруулж ажилд авах журам”-ыг эмнэлгийн Ерөнхий захирлын 2023 оны 03 дугаар сарын А/31 дүгээр тушаалаар шинэчлэн батлаж, мөрдөн ажиллаж байна. Журмыг эмнэлгийн албан ёсны цахим хуудсанд нийтэд ил тод байршуулсан. Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/564 дүгээр тушаалын дагуу Эмнэлгийн ерөнхий захирлын 2022 оны А/41 дүгээр тушаалаар “Эмнэлгийн бүтэц, орон тоо, хүний нөөцийн төлөвлөлт”-ийг 566 орон тоог 515 болгож 51 хүнээр буюу 9%–иар бууруулан эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэн ажилласан. Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл

				• https://info.shilendans.gov.mn/login “Шилэн данс”-д байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг сар бүр тайлагнасан. • Эмнэлгийн ЦАХИМ хуудасны http://ssch.gov.mn/ “АЖЛЫН БАЙРНЫ ЗАР болон эмнэлгийн албан ёсны фейсбүүк фейжд 2025 оны 12 дугаар сарын 04-ны байдлаар нийт 38 ажлын байрны нээлттэй сонгон шалгаруулалтын зарыг давхардсан тоогоор 135 удаа ил тодоор байршуулсан. 2025 оны 12 дугаар сарын 04-ны байдлаар нийт 128 ажилтныг сонгон шалгаруулж шинээр ажилд авсан. Үүнд: 18 эмч, 72 сувилагч, 10 туслах сувилагч, 28 үйлчлэгч бусад ажилтнууд байна.
1.2	Нээлттэй ажлын байранд ажилтанг хүний нөөцийг сонгон шалгаруулах журмын дагуу ил тод сонгон шалгаруулж, хүний нөөцийг бүрдүүлэх	Хүний нөөцийн ил тод байдал хангагдана.	Нээлттэй сонгон шалгаруулалтын зарлалын тоо Шинээр авсан ажилтны тоо	• Ажилд орохыг хүссэн эмнэлгийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтанг “Эрүүл мэндийн ажилтан сонгон шалгаруулж ажилд авах журам”-ын дагуу Удирдлагын зөвлөлийн хурал болон тасгийн хамт олны хурлаар хэлэлцүүлсний үндсэн дээр ил тод, нээлттэйгээр сонгон шалгаруулж ажилд авч, хөдөлмөрийн гэрээ байгуулан ажилласан. • Иргэд болон эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнаас байгууллагын хүний нөөцийн удирдлагатай холбоотой гарсан гомдол байхгүй болно. • Шинээр ажилд орсон нийт 128 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажилласан
1.3	Эмч, ажиллагсдын ажлын байрны тодорхойлолтыг мэргэжлийн төлөөлөлийн саналд тулгуурлан шинэчлэн боловсруулах	Ажил үүрэг тодорхой болж ажлын ачаалал тэнцвэртэй болно	Шинэчлэн боловсруулсан албан тушаалын тодорхойлолтын тоо	Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын 2025 оны 11-р сарын 27-ний өдрийн А/446 тоот тушаалаар “Улсын хоёрдугаар төв эмнэлгийн дүрэм, зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлах тухай” шинэчлэн батлагдсан. Үүнтэй холбоотойгоор эмч,

				эмнэлгийн ажилтан алба хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж байна. Эрүүл мэндийн сайдын “Чиглэл хүргүүлэх тухай” 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 1а/3266 тоот албан бичиг, “Байгууллагын дүрэм, бүтцийг шинэчлэн батлах тухай” 2025 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 1а/3546 дугаар албан бичгийг тус тус үндэслэн чиг үүргийн давхардлыг арилган, үйл ажиллагаа уялдаатай ажил, албан тушаалыг нэгтгэж, зарим ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх зэргээр захиргааны бүтцийг цомхон болгох зохицуулалтыг хийж, 566 орон тоог 515 болгож 51 хүнээр буюу 9%–иар бууруулсан. Мөн үйл ажиллагааны хувьд уялдаатай нэгж, албадыг нэгтгэн албадыг 11, тасгийг 23 болгон цөөрүүлсэн. Зарим тасаг нэгжийн үйл ажиллагааг нэгтгэн Төв болгон өргөжүүлсэн байна.
1.4	Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйл, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллах	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж ажилласан байна.	Хөгжлийн бэрхшээлтэй ажилтны тоо	Хөгжлийн бэрхшээлтэй албан хаагчийн нийт тоо-3
Зорилт 2. Хүний нөөцийн тогтвортой хөгжлийг хангаж, чадавхийг бэхжүүлэх				
2.1	Эмнэлгийн мэргэжилтнүүдийн тасралтгүй сургалтын багц цагийн бүрдүүлэлт 100% биелүүлэх, багц цаг бүрдүүлэлтийн 1 багц цаг	Эмнэлгийн мэргэжилтнүүдийн багц цаг бүрдүүлэлт 100% байна.	Багц цаг бүрдүүлэлтийн тайлан	Төлөвлөгөөт 28 багц цагийн сургалт 100% ийн гүйцэтгэлтэй зохион байгуулагдсан.

	нь эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, эрх зүйн чиглэлээр байх	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, эрхзүйн мэдлэгийг нэмэгдэнэ.		
2.2	Эмнэлгийн мэргэжилтнүүдийн хэрэгцээнд нийцсэн богино хугацааны тасралтгүй сургалтыг зохион байгуулах	Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн мэдлэгийг нэмэгдэнэ.	Зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан мэргэжилтнүүд ийн тоо	• Шинэ ажилтан болон 2025-2026 оны хичээлийн жилд шинээр элссэн эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтад хамрагдах эмч, сувилагч нарын чиглүүлэх сургалтыг 2025.10.16-ны өдөр зохион байгуулж нийт 98 хүн хамрагдав. Сургалт төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явагдсан. • УХТЭ-ийн Эмч, сувилагчдад сэтгэл зүйн эрүүл мэндийг дэмжих 2 • удаагийн сургалтыг НЭМ-ийн мэргэжилтнүүд зохион байгуулсан. Эмнэлгийн Дэмжих албадын ажилчдад болон эмч нарт Эрүүл зохистой хоололт сэдвээр 2 удаагийн сургалтыг тус тус НЭМ-ийн мэргэжилтнүүд зохион байгуулсан байна. • ЭМХТ-өөс зохион байгуулдаг сургагч багш бэлдэх сургалтад БМЗТ, Ангиографийн тасаг, МСТ, ЦОЭТ-ийн 4 эмч, СГХА-ны 1 ажилтныг хамруулсан. •
2.3	Лавлагаа шатлалын тусламж үйлчилгээний чиглэлүүдээр дүүрэг, орон нутгийн эмнэлгүүдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх	Үйлчлүүлэгч, иргэд орон нутагтаа чанартай тусламж үйлчилгээ авах боломжийг	Зохион байгуулсан, арга хэмжээний тайлан	АХТ-ын эрхлэгч Ц.Уянга БӨ Баяннуур, Буянт СЭМТ,ЗӨСҮТ, Дархан детект, СБДНЭ, Сон медикал эмнэлэг т магадлан итгэмжлэлийн үнэлгээ хийсэн. Мөн Баянхонгор АНЭ Өмнөговь аймгийн БОЭТ Дорнод аймгийн БОЭТ Дорноговь аймгийн Замны үүдийн нэгдсэн эмнэлгийн эмч ажилчдад ариутгал халдваргүйтгэлийн сургалт, мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгсөн.

		бүрдүүлж ажиллана.		Ерөнхий мэс заслын тасаг 2025 оны 05-р сарын 26-аас 05-р сарын 31-ны өдрүүдэд ивэрхийн мэс заслын орчин үеийн чиг хандлага сургалтыг Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлэг, 06-р сарын 02-оос 07-ны хооронд Улсын хоёрдугаар төв эмнэлэг дээр тус тус зохион байгуулсан. Японы Кансай их сургуулийн 2 профессортой хамтран UPPER GI Master class сургалтыг 2025 оны 08-р сарын 14-16-ны хооронд ерөнхий мэс заслын тасаг зохион байгуулсан. Сургалтанд улсын хэмжээний нийт 45 эмнэлгийн мэргэжилтнүүд хамрагдав. 2 удаагын мэс засал хамтарч хийсэн. 2025 оны 10 дугаар сарын 16-20 өдрүүдэд Ерөнхий мэс заслын эмч нарын баг Орхон аймагт 5 хоног олон улсын ивэрхийн сангийн 3 эмчтэй хамтарч ажлын байран дээрх ивэрхийн мэс заслын сургалт хийсэн. Баянхонгор аймгийн нэгдсэн эмнэлгийн эмч, эмнэлгийн ажилчдад эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, ариутгал халдваргүйтгэлийн чиглэлээр сургалтыг 2025.05 сард хийсэн. УХТЭ-ийн Диабетийн төвөөс "Чихрийн шижинтэй тэмцэх дэлхийн өдөр"-ийн хүрээнд Төв аймгийн нэгдсэн эмнэлгийн эмч нарт "Чихрийн шижингийн үеийн хяналт, оношилгоо, эмчилгээ" сэдэвт багц цагийн сургалтыг орж нийт 74 эмч нарыг хамруулсан. УХТЭ-ийн Эмийн эмчилгээний зохицуулах хороо, Антибиотикийн дэд хорооноос Бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх дэлхийн 7 хоногийн
--	--	-----------------------	--	--

				хүрээнд эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэдлэг хандлагыг төлөвшүүлэх хамтарсан сургалт хийж нийт 70 орчим эмч мэргэжилтэн оролцсон ба танхимаар 35, цахимаар 35 орчим оролцогчид хамрагдсан.
2.4	Эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, боловсролыг дээшлүүлэх сургалтын төлөвлөлтийг хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээ, төрөлжсөн нарийн мэргэжлийн чиглэлд нийцүүлэн гаргаж, шударга зарчмаар сонгон нэрийг дэвшүүлж хэрэгжүүлэх	Эмнэлгийн хүний нөөцийн чадавхи нэмэгдэнэ.	Сургалтад хамрагдсан мэргэжилтний тоо	2025 онд төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн дотрын анагаах ухаан судлал, дүрс оношилгоо судлал, мэс засал судлал, мэдрэл судлал, эрчимт эмчилгээ судлал, мэдээгүйжүүлэг судлал, яаралтай тусламж судлалын 7 чиглэлийн сургалтыг явуулж байна. 2024-2025 оны хичээлийн жилд нийт 98 резидент эмч суралцсан. 2025-2026 оны хичээлийн жилд 108 резидент эмч суралцаж байна. 2024-2025 оны хичээлийн жилд төгсөлтийн дараах төрөлсөн мэргэжлийн эмнэлгийн тусламжийн чанар аюулгүй байдал чиглэлээр 20 эмч, бөөр судлал чиглэлээр 1 эмч суралцсан. Төгсөлтийн дараах мэргэжил дээшлүүлэх гемодиализ судлал-5, өвдөлт намдаах менежмент-14, эмэгтэйчүүдийн дурангийн мэс засал судлал-7, хэвлийн хөндийн дурангийн мэс засал-6, дурангийн онош зүй-1, тархины судасны хэт авиан оношилгоо-3, тархины цахилгаан бичлэг-1 эмчийг сургасан.
2.5	Өндөр хөгжилтэй орны эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдтэй хамтарсан сургалт хийх	Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд эд өндөр технологи, ур чадвар шаардсан тусламж,	Сургалтын тайлан	2024 оны 10 дугаар сараас сувилагч болон эмнэлгийн бусад мэргэжилтнүүдийг Япон улсад нэг сарын хугацаатай туршлага судлуулах “Илгээлтийн эзэд” хөтөлбөр хэрэгжсэн. Энэхүү хөтөлбөрт нийт 35 ажилтан хамрагдсан бөгөөд үүнд: 18 сувилагч, 1 цахим бүртгэлийн ажилтан, 2 эдийн засагч, 1

		үйлчилгээг үзү үлэх сургалт зохион байгуулагдана.		инженер, 2 угаагч, 1 лаборант, 1 мужаан, 1 цахилгаанчин, 1 сувилахуйн арга зүйч, 1 хүний нөөцийн ажилтан, 2 нярав, 2 тогооч, 2 үйлчлэгч багтсан. • Амьд донороос бөөр шилжүүлэн суулгах ажлын хүрээнд НЛТ-ын их эмч Ш.Болортуяа болон БДШТ-ын их эмч М.Болортуяа нар Тайван улсын Тайваны их сургуулийн эмнэлэгт нэг сарын сургалтад хамрагдсан. • Мөн 2024 оны 12 дугаар сараас 2025 оны 01 дүгээр сарын хугацаанд, КОFИН төслийн хүрээнд Аж ахуй, СГХА, СА-ны нийт 5 ажилтан Солонгос улсын Самсунг Медикал төвд ажлын байран дахь сургалтад хамрагдсан. • ЯТТ-ын их эмч Х.Батхүү Солонгос улсын Pusan National University Yangsan Hospital-д 1 сарын хугацаатай сургалтад хамрагдав. /2025.06.29-2025.07.25/ • НЛТ-ын лаборант Г.Доржханд, БДШТ-ын их эмч Ж.Одгэрэл нар Тайвань улсад 1 сарын ажлын байран дахь сургалтад хамрагдлаа. /2025.08.04-2025.08.29/ • ЯТТ-ын их эмч Энэбиш, Одончимэг, НЭМ-ийн мэргэжилтан Гүнчинхорлоо, Хүүхдийн тасгийн ахлар сувилагч Номин-Эрдэнэ нар Энэтхэг улсад 1 сарын хугацаатай сургалтад хамрагдав. • ГССЗТ-ын эрхлэгч Билгүүн БНСУ-д ажлын байран дахь сургалтад 2025.08 сараас 6 сарын хугацаатай суралцаж байна. • ГССЗТ-ын эмч Очбаяр БНСУ-ын Улсан хотод сургалтад хамрагдаж байна.
--	--	--	--	--

				• ДОТ-ын техникч нар БНСУ-д ажлын байран дахь сургалт болон ОУ-ын ДО-ны техникч нарын хурал, семинарт 2025.10 сард оролцлоо. • ЕМЗТ-ын эмч Түвшинбаяр, МТА-ны даргыг түр орлон гүйцэтгэгч С.Болд нар БНХАУ-ын Шанхай хотод ажлын байран дахь сургалтад 5 хоног хамрагдав. • ДОТ-ын эмч Эрдэнэсүрэн Турк улсад Багана нурууны мурийлтын оношилгоо сэдэвт сургалтад 2025.08 сард хамрагдав. • СЗЭТ-ын их эмч Цэнд-Аюуш БНХАУ-ын Хөх хотод Сэргээн засах эмчилгээ ажлын байран дах сургалтад 2025.04 сард 14 хоног хамрагдав.
2.6	Удирдах ажилтан, эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнуудыг олон улсын болон дотоодын байгууллагын зохион байгуулж байгаа хувь хүний хөгжил, ёс зүй, манлайлал сэдэвт сургалтанд хамруулах	Байгууллагын соёл тогтворжиж, хувь хүний ёс зүй дээшилнэ.	Сургалтын тайлан	Монгол улсын эрүүл яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны 2025 оны 10-р сарын 06-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор УХТЭ-ийн Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны бүрэлдхүүний шинэчлэн баталсан. Ёс зүйн салбар хорооны даргаар Ерөнхий мэс заслын тасгийн эрхлэгч Н.Алтанчимэгээр ахлуулан 8 хүний бүрэлдхүүнтэй ажиллаж эхэлсэн. Ажиллаж эхэлснээс хойш нийт 3 удаагын Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн, хууль эрх зүйн мэдлэг олгох, Хувь хүний хөгжил, Сувилагч мэргэжлээрээ бахархах сургалтыг тус тус зохион байгуулсан.
2.7	Эмч, мэргэжилтнүүдийг эмнэл зүйн сургагч багшаар мэргэшүүлэх	Эмч,мэргэжилт нүүдийн ур, чадвар нэмэгдэж, эмнэлзүйн	Эмнэл зүйн сургагч багшийн тоо	Төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтыг удирдан зохион байгуулах эмнэлзүйн сургагч багшийн шалгуурыг хангасан 5 эмч хувын зардлаар хамрагдсан.

		сургагч нарын нөөц бүрдэнэ.		
2.8	Ажилтнуудын ажлын идэвхийг тогтмол сэргээхэд чиглэсэн ажил, мэргэжлийн болон ур чадварын уралдаан, тэмцээнийг тогтмол явуулах, урамшуулах	Ажилтнуудын идэвхи дээшилж, найрсаг, эвсэг хамт олон байх нөхцөл бүрдэнэ.	Зохион байгуулагдсан үйл ажиллагааны тоо, тайлан	- Үйлдвэрчний эвлэлийн нэрэмжит байгууллагын аварга шалгаруулах 5 төрөлт тэмцээн 06 дугаар сарын 09-өөс 17-ны өдрүүдэд амжилттай болж зохион байгуулагдсан. - Сувилахуйн албанаас жил бүр тогтмол хугацаанд Сувилагч болон туслах сувилагч нарын дунд мэргэжил болон ур чадварын сургалт, уралдаан явуулдаг. - 2024 оны 09-р сарын 13-ний өдрийн А/163 дугаар тушаалаар Мэргэжлийн кареерийн шатлалын тухай тушаалаар нийт 7 сувилагч 2025 онд үндсэн цалингийн 20%-иар нэмэгдэл цалин, урамшуулал авч ажилласан.
2.9	Эрүүл мэндийн ажилтнуудыг мэргэжлийн болон боловсролын зэрэг хамгаалахад дэмжлэгт орчин бүрдүүлэх	Ажилтны мэргэжлийн ур чадвар, боловсрол дээшилнэ	Тухайн жилд боловсролын болон мэргэжлийн зэрэг ахиулсан ажилтны тоо, хувь	Улсын хоёрдугаар төв эмнэлгийн ерөнхий захирлын 2025 оны 06 дугаар сарын 16-ний өдрийн А/180 дугаар тушаалаар томилогдсон тушаалаар Мэргэжлийн зэргийн шалгалтанд Зөвлөх эмч-1, Тэргүүлэх эмч-5, Ахлах эмч- 21, Зөвлөх сувилагч-2, Тэргүүлэх сувилагч-1, Ахлах сувилагч- 6. Магистрантур-7, Докторантур-4, Магистрийн зэрэг хамгаалсан-1.
2.10	Мөнгөн ба мөнгөн бус урамшууллын тогтолцоогоор ажлын гүйцэтгэлийг сайжруулах хөшүүрэг болгох	Ажилтны идэвхи дээшилнэ.	Мөнгөн ба мөнгөн бус урамшуулал авсан ажилтны бүртгэл судалгаа	• Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72,1 дэх заалт, Эмнэлгийн ерөнхий захирлын 2020 оны А/59 дугаар тушаалын дагуу Шөнийн цагт ажилласны нэмэгдэл 82347 цагийн 176,106,000 төгрөг олгогдсон. • Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн дагуу илүү цагаар болон 7 хоногийн амралт, нийтээр амрах баяр ёслолын өдөр ажиллуулсны хөлс болох 4,801,832,608

				төгрөгийг давхардсан тоогоор нийт 557 эмнэлгийн эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн, ажилтанд олгосон. • Дуудагдан ажилласны хөлс болох 408,578,896 төгрөгийг давхардсан тоогоор нийт 272 эмнэлгийн эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн, ажилтанд олгосон. • Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 22.1 дэх заалтын дагуу эмнэлгийн хэмжээнд Анагаах ухааны доктор 10, Зөвлөх эмч 11, Зөвлөх сувилагч 3, Тэргүүлэх эмч 38, Тэргүүлэх сувилагч 41, Ахлах эмч 35, Ахлах сувилагч 23, бусад мэргэжилтэн 9 нийт 170 ажилтанд боловсролын болон зэргийн нэмэгдлийг үндсэн цалингийн 10-20 хувиар тус тус тооцон 376,832,964 төгрөгийн нэмэгдэл олгосон • Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 151 дүгээр тогтоолын дагуу төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл нийт 635 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд 880,717,481 төгрөгийн нэмэгдэл хөлс олгосон. • Хөдөлмөрийн тухай хуулийн 108.1 дүгээр заалт, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2004 оны 77 дугаар тушаалын дагуу хөдөлмөрийн хэвийн бус нөхцлийн нэмэгдэл 408,226,973 төгрөгийг 293 эмнэлгийн эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн, ажилтанд олгосон. • Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 06 дугаар тогтоолын хавсралтын дагуу хоол, унааны нэмэгдэл 1,285,296,00 төгрөгийг 716 ажилтанд олгосон.
--	--	--	--	---

			- Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтад заасны дагуу ур чадварын нэмэгдлийг 60 ажилтанд 10%-иар тооцон нийт 128,458,681 төгрөг тооцон олгосон. - Эмнэлэг сувилахуйн болон тусгай мэргэжилтний хомсдолд орж ажлын байрны ажлын ачаалал эрс нэмэгдсэнтэй холбоотой Ерөнхий захирлын 2022 оны А/99 дугаар тушаалаар 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн сувилахуйн болон тусгай мэргэжилтнүүдэд үндсэн цалингийн 15 хувийн нэмэгдлийг олгон ажиллаж байна. - Хангамж, үйлчилгээний хэсгийн үйлчлэгчийн ажлын байранд ажиллах ажилтны хомсдол үүсч, батлагдсан орон тооноос нэн дутуу ажиллан нэг үйлчлэгчид ноогдох ажлын ачаалал эрс нэмэгдсэн тул Ерөнхий захирлын 2022 оны Б/313 дугаар тушаалаар 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн үндсэн цалингийн 20%-ийн нэмэгдэл олгон ажиллаж байна. Эрүүл мэндийн салбарын ажилтны баярын өдрөөр Эрүүл мэндийн яамны жуух бичгээр эмч-3, рентген техникч-3 сувилагч-2, цахим бүртгэл, лавлагааны ажилтан-3, инженер-1, эмнэлгийн тоног төхөөрөмжийн техникч-1 нийт 13 ажилтан, Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан тэмдгээр эмч-4, сувилагч-ариутгагч-1 нийт 5 ажилтан, хамтран ажиллагч байгууллагын гарын бэлгээр нийт 20 ажилтныг тус тус шагнаж урамшуулсан.
--	--	--	--

2.11	Үр дүнгийн урамшууллыг Засгийн газрын холбогдох тогтоолын дагуу хэрэгжүүлэх	Ажилтны тогтвортой ажиллах боломж, сэтгэл ханамж нэмэгдэнэ	Үр дүнгийн урамшууллын дүн тайлан	Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 05, 395 дугаар тогтоолоор тус тус батлагдсан "Эрүүл мэндийн ажилтанд нэмэгдэл, мөнгөн урамшил олгох журам"-ын дагуу Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан бүрийн ажлын гүйцэтгэлийг шалгуур үзүүлэлтийн дагуу алба, тасгийн хамт олноор ил тодоор үнэлүүлдэг 647 ажилтанд 1,651,318,351 төгрөг (Эмнэлгийн ерөнхий захирлын 2025 оны тушаал)
Зорилт 3. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг хангах				
3.1	Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 193 дугаар тогтоолоор батлагдсан "Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх	Чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, сэтгэл ханамж нэмэгдэнэ	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	2025 онд Япон улсад туршлага судалсан илгээлтийн эзэд хөтөлбөрөөр нийт 23 эмнэлгийн мэргэжилтэн (сувилагч, нярав, үйлчлэгч, инженер, эдийн засагч гэх мэт) ажлын байран дахь сургалтад хамрагдсан. - УХТЭ-н захирлын 2024 оны 09 дүгээр сарын 16-ний өдрийн А/158 тоот тушаалын дагуу И/240901-52-25/126 тоот гэрээний дагуу Ажилчдын дотуур байрыг тохижуулан сувилахуйн албаны нийт 8 ажилчдыг байраар хангасан.

Тайлан гаргасан / П.Уянгасайхан /